



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/136

Улаанбаатар хот


Худалдан авах ажиллагаа
зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Нийслэлийн 2019 оны төсөвт зохицуулалт, нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 23/15 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 60 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Эрх шилжүүлэх тухай” А/137 дугаар захирамж, 2019 оны А/298 дугаар захирамж, 2019 оны А/424 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.21 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/424 дүгээр “Эрх шилжүүлэх тухай” захирамжийн 3 дахь заалтад зааснаар Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/298 дугаар “Эрх шилжүүлэх тухай” захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх авто зам, засварын ажлын жагсаалт”-ын 3, 12 дахь хэсгийг хүчингүй болгосонтой холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/106 дугаар “Худалдан авах ажиллагаа зохион байгуулах тухай” тушаалын 2 дахь заалтад заасан 3, 12 дахь ажлуудыг хүчингүй болсонд тооцсугай.

2. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дүгээр сарын 09-ны өдрийн А/424 дугаар “Эрх шилжүүлэх тухай” захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх авто замын засвар, шинэчлэлийн ажлын жагсаалт”-ын 1, 2, 3, дахь ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 48 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороонд даалгасугай.

3. Дээрх ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, зөвлөмжийг Нийслэлийн Авто замын хөгжлийн газарт хүргүүлж ажиллахыг Үнэлгээний хороо /Ц.Рэгзэдмаа/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

